

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.5 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.6 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорил, түүний үр дүн.....	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	7
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	13
2.11 Шилэн дансны мэдээлэл .....	13
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	13
2.13 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
3. Менежментийн захидал.....	15
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	18
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	18
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	18
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	19
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	21
5. Хавсралт .....	22

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖС	Байгаль, орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль, орчин, аялал жуулчлалын яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШУА	Шинжлэх ухааны академи



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН  
ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Б.АВИД ТАНАА

2020.03.24 № 06/321  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Шинжлэх ухааны академийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинжлэх ухааны академийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Шинжлэх ухааны академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Шинжлэх ухааны академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Авид Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгө, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шинжлэх ухааны академийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинжлэх ухааны академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 4-өөс 3 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж, гэрээт ажилтан М.Ганбаатар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шинжлэх ухааны академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 4/62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шинжлэх ухааны академийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинжлэх ухааны салбарын онцлог, эрх зүйн актуудын шинэчлэлтэй холбогдуулан сайжруулан боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, эрдэм шинжилгээний ажлын суурь судалгаа, төсөл хөтөлбөрийн үр дүнг дутуу тооцогдох зэрэг үр дагавартай байна.

Шинжлэх ухааны академийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **2.5 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Шинжлэх ухааны академийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.6 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 22,579.5 сая төгрөгийн 2 хувь буюу 451.6 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

## 2.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа эрдэм шинжилгээний 17 хүрээлэн, тэргүүлэгчдийн газар, нийт 18 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 10 байгууллага аудитад хамрагдсан, 5 байгууллага аудитын түүвэрт хамруулж, мөн Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор 3 эрдэм шинжилгээний хүрээлэн татан буугдсан шалтгаанаар аудитад хамрагдаагүй.

Аудитад хамрагдсан харьяа 10 эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Шинжлэх ухааны академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 15,904.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 15,828.9 сая төгрөгийн 53 алдааг аудитын явцад залруулж, 7.1 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 68.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 28 зөвлөмжийг хүргүүлээ.

### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд 8,802.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн өсөлт бууралт мөрийг илүү, 8,802.2 сая төгрөгөөр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт мөрийг дутуу нэгтгэсэн;

Төвлөрүүлсэн захирагчид 4.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Шинжлэх ухааны академийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 71.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 7.1 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 64.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 24 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 7,026.7 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд Түүх, угсаатны зүйн хүрээлэн 7.9 сая, Биологийн хүрээлэн 4.6 сая, Математик, тоон технологийн хүрээлэн 0.3 сая, нийт 12.9 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг дутуу, Геологийн хүрээлэн 0.3 сая төгрөгөөр татаас санхүүжилтийн авлагыг илүү, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 7.7 сая, Биологийн хүрээлэн 4.6 сая, Геологийн хүрээлэн 0.3 сая, нийт 12.6 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүн дутуу, Математик, тоон технологийн хүрээлэн 0.3 сая төгрөгөөр төрийн өмчийг дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд Палеонтологи, Геологийн хүрээлэн 23.0 сая, Одон орон, геофизикийн хүрээлэн 10.2 сая, нийт 33.2 сая төгрөгөөр төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого дутуу, Палеонтологи, геологийн хүрээлэн 23.0 сая, Одон орон, геофизикийн хүрээлэн 10.2 сая, нийт 33.2 сая төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийг илүү, Түүх, угсаатны

зүйн хүрээлэн 7.6 сая, Математик, тоон технологийн хүрээлэн 0.3 сая, нийт 7.9 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу, Геологийн хүрээлэн 0.3 сая, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 0.2 сая, нийт 0.5 сая төгрөгөөр төвлөрүүлэх шилжүүлэг дутуу, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 0.2 сая төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг илүү, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 0.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол илүү нэгтгэсэн;

- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд Палеонтологи, Геологийн хүрээлэн 23.0 сая төгрөгөөр төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого дутуу, 23.0 сая төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийг илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд Биологийн хүрээлэн 2,634.3 сая, Математик, тоон технологийн хүрээлэн 44.6 сая, нийт 2,680.0 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт илүү, Биологийн хүрээлэн 2,511.9 сая, Математик, тоон технологийн хүрээлэн 44.6 сая, нийт 2,560.0 сая төгрөгөөр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дутуу, Биологийн хүрээлэн 122.4 сая төгрөгөөр өмнөх оны үр дүн дутуу, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 7.7 сая, Биологийн хүрээлэн 4.6 сая, Математик, тоон технологийн хүрээлэн 0.3 сая, нийт 12.6 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүн дутуу, Геологийн хүрээлэн 0.3 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүн илүү нэгтгэсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд Биологийн хүрээлэн 5.6 сая, Философийн хүрээлэн 2.5 сая, нийт 8.1 сая төгрөгөөр улсын төсвийн санхүүжилтийг дутуу, Философийн хүрээлэн 2.5 сая төгрөгөөр урсгал шилжүүлгийг дутуу нэгтгэсэн;
- Нэмэлт санхүүжилтийн тайланд Хими, химийн технологийн хүрээлэн 382.9 сая, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 44.9 сая, Археологийн хүрээлэн 6.5 сая, Палеонтологийн хүрээлэн 5.7 сая, Геологийн хүрээлэн 0.3 сая, Одон орон, геофизикийн хүрээлэн 0.2 сая, Тэргүүлэгчдийн газар 0.1 сая, нийт 440.6 сая төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг илүү, Хими, химийн технологийн хүрээлэн 324.5 сая, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 44.9 сая, Палеонтологи, геологийн хүрээлэн 23.0 сая, Археологийн хүрээлэн 3.7 сая, Геологийн хүрээлэн 0.3 сая, нийт 396.4 сая төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийг илүү, Хими, химийн технологийн хүрээлэн 286.6 сая, Палеонтологи, геологийн хүрээлэн 23.0 сая, нийт 309.6 төгрөгөөр Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого дутуу, Археологийн хүрээлэн 1.4 сая төгрөгөөр төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого илүү, Хими, химийн технологийн хүрээлэн 345.0 сая төгрөгөөр төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийг илүү нэгтгэсэн;
- Нэгтгэгдсэн байгууллага хооронд болон төсвийн төвлөрүүлэн захирагч хооронд үүссэн 0.5 сая төгрөгийн давхардсан орлого болон зардлын давхардсан ажил гүйлгээний устгах бичилтийг дутуу тайлагнажээ;

## 2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3.6 сая, эцсийн үлдэгдэл 366.6 сая төгрөг болж, 363.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	2.6	-	(2.6)	
Банканд байгаа бэлэн мөнгө	1.0	366.6	365.6	100.0
<b>Дүн</b>	<b>3.6</b>	<b>366.6</b>	<b>363.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Шинжлэх ухааны Академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд байгаа 366.6 сая төгрөг Палеонтологийн хүрээлэнгийн Төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн 100900015901 тоот харилцах дансанд байршиж байна.

### 2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 908.0 сая, эцсийн үлдэгдэл 549.2 сая төгрөг болж, 358.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.4	0.1	(2.3)
Төлбөртэй үйлчилгээний авлага	70.7	-	(70.7)
Татаас, санхүүжилтийн авлага	804.0	532.0	(272)
Бусад авлага	30.9	17.1	(13.8)
<b>Дүн</b>	<b>908.0</b>	<b>549.2</b>	<b>(358.8)</b>

Эх сурвалж: Шинжлэх ухааны Академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хими, хими технологийн хүрээлэн 380.2 сая, Газарзүй, гео-экологийн хүрээлэн 93.2 сая, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 44.7 сая, Философийн хүрээлэн 8.9 сая, Археологийн хүрээлэн 4.5 сая, Геологийн хүрээлэн 0.3 сая, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 0.2 сая, нийт 532.0 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага байна.

Археологийн хүрээлэн 3.3 сая, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 1.3 сая, Хими, хими технологийн хүрээлэн 0.1 сая, нийт 4.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Түүх, угсаатны зүйн хүрээлэн 12.3 сая, Тэргүүлэгчдийн газар 0.2 сая, нийт 12.5 сая төгрөгийн бусад байгууллагаас авах авлага байна.

### 2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 33.0 сая, эцсийн үлдэгдэл 208.3 сая төгрөг болж, 175.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	32.4	205.8	173.4
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.6	2.5	1.9
<b>Дүн</b>	<b>33.0</b>	<b>208.3</b>	<b>175.3</b>

Эх сурвалж: Шинжлэх ухааны Академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хими, хими технологийн хүрээлэн 146.0 сая, Математик, тоон технологийн хүрээлэн 30.7 сая, Тэргүүлэгчдийн газар 17.5 сая, Палеонтологийн хүрээлэн 14.1 сая, нийт 208.3 сая төгрөгийн урьдчилгаа дансны үлдэгдэл байна.

- БОАЖС-ын 2019 оны А/795 дугаар тушаалаар Сайжруулсан түлш, чанарын хяналт, орчны бохирдлын хяналт шинжилгээнд зориулж, “Хий, шингэний хроматограф” багаж авахад шаардагдах зардал 292.0 сая төгрөгийг БОАЖЯ-аас ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнд шилжүүлж, багажийн урьдчилгаа төлбөрт 146.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.
- Математик, тоон технологийн хүрээлэнд хэрэгжиж байгаа “Сплайн функц болон интеграцийн аргын онол, хэрэглээ”, “Цагаригийн радикалын онол, түүний математикийн бусад салбаруудтай холбогдох нь”, “Операторын онол, хэрэглээ”, “Алсын геометр ба К-онол” сэдэвт суурь судалгааны 4 төслийн зардал 30.7 сая төгрөгийг бүртгэсэн байна.

- Тэргүүлэгчдийн газар “Амьдралыг тэтгэх тогтолцоо” нэвтэрхий толь 3 боть номын хэвлэх зардлын урьдчилгаа 16.4 сая, шуудангийн зардлын урьдчилгаа 0.5 сая, онгоцны билетийн урьдчилгаа 0.6 сая, нийт 17.5 сая төгрөгийн төлбөр байна.
- Палеонтологийн хүрээлэнгийн захирлын 2019 оны Б/35 дугаар тушаалаар 4 эрдэм шинжилгээний ажилтан АНУ-ын Иллионис мужийн Гленц, Чикаго хотын Ботаникийн хүрээлэн хооронд байгуулсан гэрээний дагуу Монгол орны хожуу Юри, түүрүү Цэрдийн эртний ургамлын судалгаа боловсруулалтын ажлын томилолтын замын зардалд 12.0 сая төгрөгийг шилжүүлсэн /түр хугацаагаар хойшлогдсон/ Шатахууны төлбөрийн урьдчилгаа төлбөр 2.0 сая төгрөг байна.

## 2.8.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 974.2 сая, эцсийн үлдэгдэл 938.1 сая төгрөг болж, 36.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	290.5	285.6	(4.9)
Бэлэн бүтээгдэхүүн	15.4	0.7	(14.7)
Бичиг хэргийн материал	58.2	43.2	(15.0)
Аж ахуйн материал	257.6	296.3	38.7
Сэлбэг хэрэгсэл	48.5	46.5	(2.0)
Түлш, шатах тослох материал	37.0	9.7	(27.3)
Барилгын засварын материал	12.3	14.7	2.4
Бусад хангамжийн материал	254.6	241.3	(13.3)
<b>Дүн</b>	<b>974.2</b>	<b>938.1</b>	<b>(36.1)</b>

Эх сурвалж: Шинжлэх ухааны Академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд худалдан авсан 1,130.7 сая, хандиваар 4.0 сая, бусад 1.2 сая, нийт 1,136.0 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн ба худалдсан, зарцуулсан 1,153.8 сая, бусад 18.1 сая, нийт 1,172.0 сая төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолын дагуу хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөр хүрээлэнгүүд хооронд 377.1 сая төгрөгийн бараа материал шилжүүлсэн байна. Энэ нь бүтцээр татан буугдсан Палеонтологи, геологийн хүрээлэн 183.3 сая, Түүх, археологийн хүрээлэн 144.6 сая, Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн 64.3 сая, нийт 392.2 сая төгрөгийн оны эхний үлдэгдлээс 15.1 сая төгрөгийн хөдөлгөөний бууралтыг хассан ба шинээр зохион байгуулагдсан хүрээлэнгүүдэд шилжүүлэн Палеонтологийн хүрээлэн 154.6 сая, Түүх, угсаатны зүйн хүрээлэн 103.2 сая, Биологийн хүрээлэн 61.5 сая, Геологийн хүрээлэн 27.5 сая, Археологийн хүрээлэн 27.2 сая, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 3.3 сая, нийт 377.3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Оны эхний бараа материалын үлдэгдлээс Философийн хүрээлэн 18.0 сая, Физик, технологийн хүрээлэн 8.9 сая, Тэргүүлэгчдийн газар 5.5 сая, Хэл зохиолын хүрээлэн 3.7 сая, Олон улсын харилцааны хүрээлэн 3.6 сая, Математик, тоон технологийн хүрээлэн 1.8 сая, нийт 41.5 сая төгрөгөөр нэмэгдэж, Одон орон, геофизикийн хүрээлэн 26.7 сая, Хими, химийн технологийн хүрээлэн 20.4 сая, Газарзүй, геоэкологийн хүрээлэн 15.6 сая, нийт 104.2 сая төгрөгөөр буурсан байна.

## 2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 30,706.8 сая, эцсийн үлдэгдэл 32,570.7 сая төгрөг болж, 1,863.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>24,600.7</b>	<b>26,547.4</b>	<b>1,946.7</b>
Барилга, байгууламж, орон сууц	18,273.4	19,868.4	1,594.9

Авто-тээврийн хэрэгсэл	134.4	244.7	110.3
Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,852.8	3,154.6	301.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	478.4	723.5	245.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,103.2	2,103.2	
Бусад үндсэн хөрөнгө	535.9	222.2	(313.7)
Дуусаагүй барилга, байгууламж	3.6	3.6	
Ном	218.9	227.1	8.2
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>6,106.1</b>	<b>6,023.4</b>	<b>(82.7)</b>
Программ хангамж	379.5	346.7	(32.8)
Бусад биет бус хөрөнгө	5,726.6	5,676.6	(50.0)
<b>Дүн</b>	<b>30,706.8</b>	<b>32,570.7</b>	<b>1,863.9</b>

Эх сурвалж: Шинжлэх ухааны Академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,863.9 сая төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө 183.9 сая, хуримтлагдсан элэгдэл 1,680.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 812.1 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 11,770.9 сая, шилжүүлэн авсан 2,682.0 сая, бусад 418.5 сая, нийт 15,683.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн, акталсан 744.8 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 14,733.1 сая, шилжүүлсэн 21.7 сая, нийт 15,499.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагджээ.

Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор Палеонтологи, геологийн хүрээлэн, Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, Түүх, археологийн хүрээлэн татан буугдсан.

Дээрх хүрээлэнгүүд оны эхэнд 14,733.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байснаас тайлант хугацаанд байгуулсан хуримтлагдсан элэгдэл 2,973.1 сая төгрөгийг хасч, ШУТС-гийн харьяа Математикийн хүрээлэнгээс 10.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авч, нийт 11,770.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шинээр зохион байгуулсан Палеонтологийн хүрээлэн, Геологийн хүрээлэн, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Археологийн хүрээлэн, Биологийн хүрээлэн, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, Математик, тоон технологийн хүрээлэнгүүдэд шилжүүлсэн байна.

ТӨБЗГ-ын 13 албан бичгийн дагуу 745.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсныг нэр бүхий хүрээлэнгүүд 744.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө актлаж, 1.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаагүй үлдээсэн байна.

Горхи Тэрэлжийн Байгалийн Цогцолбор тусгай хамгаалалттай газарт байрладаг Тэрэлж голын эх Даваат гэдэг газар 2008 онд нутгийн иргэдийн хандиваар барьсан 4x5 метрийн хэмжээтэй суурьгүй модон торхыг ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн /Хуучнаар Газарзүйн хүрээлэн/-ийн санхүүгийн тайланд 2008 онд 3.6 сая төгрөгөөр дуусаагүй барилгад бүртгэсэн байна.

Газарзүй, гео-экологийн хүрээлэнгийн Ойт-хээрийн суурин судалгааны станц Даваатын аманд 2007 оноос ажиллаж, уур амьсгал, хөрс, цэвдгийн 10 гаруй үзүүлэлтүүдийг автомат станцаар хэмжилт хийж байна.

### 2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 20.7 сая, эцсийн үлдэгдэл 3.0 сая төгрөг болж, 17.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	13.7	0.7	(13.0)	23.3
Байгууллагад төлөх өглөг	5.4	2.3	(3.1)	76.7
Хувь хүмүүст төлөх өглөг	1.6	-	(1.6)	
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>	<b>20.7</b>	<b>3.0</b>	<b>(17.8)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Шинжлэх ухааны Академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн Улаанбаатар цахилгаан түгээхэд 1.3 сая, Гео Сүрвэйс Интернейшнл ХХК-д 0.2 сая, Археологийн хүрээлэн үйлдвэрчний эвлэлд 0.8 сая, Философийн хүрээлэн ХХОАТ-д 0.7 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

## 2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 32,604.8 сая, эцсийн үлдэгдэл 34,630.1 сая төгрөг болж, 2,025.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	20,061.0	23,944.6	3,883.6	69.1
Хуримтлагдсан үр дүн	(3,697.9)	793.8	4,491.7	2.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,241.7	9,891.7	(6,350.0)	28.6
<b>Дүн</b>	<b>32,604.8</b>	<b>34,630.1</b>	<b>2,025.3</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Шинжлэх ухааны Академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

2018 онд хийгдсэн үл хөдлөх хөрөнгө болон биет бус хөрөнгийн дахин үнэлгээгээр үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс руу, биет бус хөрөнгийн үнэлгээг Засгийн газрын сан руу тус тус бүртгэжээ.

Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор татан буугдсан хүрээлэнгүүдийн 2019 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхдээ хөрөнгийг үлдэх өртгөөр нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэлд тусгаж, Засгийн газрын санг өсгөсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт нь 14,061.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 8,733.8 сая төгрөгөөр хасагдаж, зөрүү нь 5,327.8 сая төгрөг байна.

*Хүснэгт №8 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт /сая төгрөг/*

Д/д	Хүрээлэнгийн нэр	Эцсийн үлдэгдэл	Тайлбар
1.	Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн	7,602.5	Тус хүрээлэнгээс Биологийн болон Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнд шилжүүлсэн хөрөнгө болон өмнөх үеийн үр дүн дансанд хаасан авлага, өглөгийн зөрүү дүн.
2.	Палеонтологи, геологийн хүрээлэн	3,334.6	Тус хүрээлэнгээс Палеонтологийн болон Геологийн хүрээлэнд шилжүүлсэн хөрөнгө болон өмнөх үеийн үр дүн дансанд хаасан авлага, өглөгийн зөрүү дүн.
3.	Түүх, археологийн хүрээлэн	3,056.5	Тус хүрээлэнгээс Түүх, угсаатны зүйн болон Археологийн хүрээлэнд шилжүүлсэн хөрөнгө болон өмнөх үеийн үр дүн дансанд хаасан авлага, өглөгийн зөрүү дүн..
4.	Хими, химийн технологийн хүрээлэн	65.6	Актлагдсан хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү.
5.	Тэргүүлэгчдийн газар	1.4	Актлагдсан хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 0.6 сая, тооцооллын алдаанаас үүссэн 0.7 сая төгрөгийн авлагыг тус тус бодлогын өөрчлөлт данс руу хаав.
6.	Хэл зохиолын хүрээлэн	1.0	Актлагдсан хөрөнгийг данснаас хассан.
7.	Палеонтологийн хүрээлэн	(3,650.8)	Палеонтологи, геологийн хүрээлэнгээс авсан хөрөнгө болон хоорондын тооцоогоор шилжүүлэн авсан авлага, өглөгийн зөрүү дүн.
8.	Биологийн хүрээлэн	(2,511.9)	Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгээс шилжүүлэн авсан хөрөнгө болон хоорондын тооцоогоор шилжүүлэн авсан авлага, өглөгийн зөрүү дүн.

9.	Түүх, угсаатны зүйн хүрээлэн	(2,070.0)	Түүх, археологийн хүрээлэнгээс шилжүүлэн авсан хөрөнгө болон хоорондын тооцоогоор шилжүүлэн авсан авлага, өглөгийн зөрүү дүн.
10.	Археологийн хүрээлэн	(342.9)	Түүх, археологийн хүрээлэнгээс шилжүүлэн авсан хөрөнгө.
11.	Геологийн хүрээлэн	(72.5)	Палеонтологи, геологийн хүрээлэнгээс шилжүүлэн авсан хөрөнгө.
12.	Газарзүй, гео-экологийн хүрээлэн	(71.9)	Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгээс авах 69.5 сая, Солонго пресс ХХК-аас авах 1.1 сая, Сангийн яамнаас татаас санхүүжилтийн авлага 1.2 сая, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалаас авах 0.1 сая төгрөгийн авлагыг тус тус данснаас хассан.
13.	Математик, тоон технологийн хүрээлэн	(13.8)	Математикийн болон Физик, технологийн хүрээлэнгээс шилжүүлэн авсан хөрөнгө болон урьдчилж гарсан зардлыг өмнөх үеийн үр дүнгээс шилжүүлэн авсан зардлын зөрүү.
<b>Дүн</b>		<b>5,327.8</b>	

Эх сурвалж: Шинжлэх ухааны Академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Шинжлэх ухааны академи тайлант онд 222.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 215.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 3.3 хувиар тасарсан байна.

Энэ нь Түүх, угсаатны зүйн хүрээлэн 7.3 сая, Палеонтологийн хүрээлэн 3.7 сая, Одон орон, Геофизикийн хүрээлэн 1.1 сая, Олон улсын харилцааны хүрээлэн 1.1 сая, Палеонтологи, геологийн хүрээлэн 0.5 сая, Түүх, археологийн хүрээлэн 0.3 сая, Хими, химийн технологийн хүрээлэн 0.1 сая, нийт 14.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс дутуу, Биологийн хүрээлэн 5.5 сая, Философийн хүрээлэн 0.6 сая, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 0.5 сая, Газарзүй, гео-экологийн хүрээлэн 0.1 сая, нийт 6.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс илүү орлого бүрдүүлжээ.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 16,820.4 сая төгрөгийн урсгал зардлын төсөв батлагджээ.

Нийт зардлын 16,592.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 222.4 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 16,592.0 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 215.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 16,791.4 сая төгрөгийг зарцуулж, 16.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Оны эхэнд 3.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол дээд шатны төсвийн захирагчаас 2,500.9 сая, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 2,363.4 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 733.8 сая, нийт 5,598.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжид 2,768.6 сая, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 625.8 сая, эд, хогшил, урсгал засварын зардалд 565.4 сая, томилолт, зочны зардалд 325.9 сая, хангамж, бараа материалын зардалд 183.4 сая, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 120.4 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 62.2 сая, бусад урсгал шилжүүлэг 34.6 сая, байр ашиглалтын тогтмол зардалд 7.0 сая, нийт 4,693.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 541.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн, 366.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

## 2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн авч үзэх буюу анхаарал татахуйц асуудал гараагүй.

## 2.11 Шилэн дансны мэдээлэл

Шинжлэх ухааны академи Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 1,857 мэдээлэл байршуулахаас 1,837 мэдээлэл хугацаандаа байршуулж, 20 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна. байгууллагын мэдээллийг ангилал тус бүрээр нь авч үзвэл:

*Хүснэгт №10 Шилэн дансанд байршуулсан мэдээлэл /тоогоор/*

№	Мэдээллийн нэр	Байршуулах шилэн дансны мэдээлэл		
		Нийт	Хугацаанд нь	Хугацаа хоцроосон
6.1.1	Тухайн жилийн төсвийн мэдээлэл	18	18	
6.1.1	ОНХС-ийн төлөвлөгөө	18	18	
6.1.2	Төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл	235	217	18
6.1.3	Дараа жилийн төсвийн төслийн мэдээлэл	11	11	
6.1.4	Санхүүгийн тайлан хагас болон жилийн эцсийн мэдээлэл	26	26	
6.1.5	ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	22	22	
6.1.6	Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	59	59	
6.4.1	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн мэдээлэл	18	18	
6.4.2	Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн мэдээлэл	108	107	1
6.4.3	Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	54	53	1
6.4.4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	217	217	
6.4.5	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	393	393	
6.4.6	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээлэл	191	191	
6.4.7	Байгууллагын баталсан оронд орсон өөрчлөлтийн мэдээлэл	68	68	
6.4.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүссэн аливаа шийдвэрийн мэдээлэл	369	369	
6.10	Нийт албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9 дүгээр зүйлд заасан мэдээлэл	50	50	
	<b>Нийт дүн</b>	<b>1857</b>	<b>1837</b>	<b>20</b>

*Эх сурвалж: Шинжлэх ухааны Академийн 2019 оны шилэн дансны мэдээллийн нэгтгэл*

## 2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 4.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 16.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 303.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 23 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### **2.13 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Шинжлэх ухааны академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шинжлэх ухааны академийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. Дотоод хяналттай холбоотой асуудал

##### 3.1.1. Илрүүлэлт:

Шинжлэх ухааны академийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн ажлын цагийн бүртгэл хангалтгүй байна. Цаг бүртгэлийн системээр ажлын цаг бүртгэсэн ч ажлын цагийн балансыг ажилласан цаг, өдрөөр биш бүрэн ажилласнаар гаргаж цалин олгож байгаагаас зарим ажилтан огт цаг бүртгүүлэхгүй, зарим нэг ажилтан шөнийн цагаар ажилладаг зэрэг зөрчлүүд байна. Мөн үндсэн ажлаас гадуур ажил эрхэлж байгаа 35 хүний ажлын цаг бүртгэгдэхгүй цалинжиж байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх, ажилтнаас хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, энэ хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх эрхтэй”, 5.2-т “Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй”, 49 дүгээр зүйлийн 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно”, 49.5-д “Ажилтан өөрийн буруугаас хөдөлмөрийн нормоо биелүүлээгүй бол гүйцэтгэсэн ажилд нь тохирсон цалин хөлс олгоно”, 70 дугаар зүйлийн 70.1-д “Долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1/77 албан даалгаврын 3-д “ажилчин, албан хаагчдын ирц, ажлын цагийн ашиглалт, ба нягтралыг сайжруулах, сар бүр нийт эрдэм шинжилгээний ажилтны 10-аас доошгүй хувийг хамарсан ажлыг цаг ашиглалтын хронометраж хийх, ажлын байрны дэг журмыг чанд сахиулах арга хэмжээ авч, ажлын үр ашгийг дээшлүүлэх” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.



### 3.1.2. Эрсдэл:

Хөдөлмөрийн тухай хуулийн зарим заалтууд болон хөдөлмөрийн гэрээ, байгууллагын дотоод журмын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, цалин хөлсийг буруу тооцож олгосон байх, ажлын чанарт нөлөөлөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

### 3.1.3. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн тухай хуулийн 5.1, 5.2, 49.1, 49.5, 70.1 дэх заалтууд болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 18.1 дэх заалтууд, хөдөлмөрийн гэрээ, байгууллагын дотоод журмыг мөрдөж ажиллах, ажлын цагийн бүртгэлийг зохих журмын дагуу бүртгэж байх, цалин хөлсийг цагийн бүртгэлийг үндэслэн тооцож олгож байх;

### 3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

## 3.2. **Балансын данстай холбоотой асуудал**

### 3.2.1. Илрүүлэлт:

1. Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор оны эхний 14,733.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнөөс хуримтлагдсан элэгдэл 2,973.1 сая төгрөгийг хасч, ШУТС-гийн харьяа Математикийн хүрээлэнгээс 10.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авч, нийт 11,770.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэр бүхий 7 хүрээлэнгүүдэд шилжүүлэн өгч, шинээр байгуулсан нь ТӨБЗГ-ын 2019 оны 430 дугаар тогтоолоор ШУА-ийн харьяа, бүтцийн өөрчлөлтөд хамрагдсан хүрээлэнгүүдийн 3,996.2 сая төгрөгийн үлдэх үнэтэй үндсэн хөрөнгийг шилжүүлэхээр шийдвэрлэсэн нь 7,774.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
2. Тайлант онд ТӨБЗГ-ын 13 албан бичгийн дагуу 745.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсныг нэр бүхий хүрээлэнгүүд 744.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө актлаж, 1.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаагүй үлдээсэн байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1-д “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ”, 5.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь ТӨБЗГ-ын шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, санхүүгийн тайланд хөдлөл өөрчлөлтийг тусгана”, 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ”, 9.1-д “Эрх бүхий байгууллагын шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хийсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн болон хөрөнгийн үнэлгээний залруулгыг холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу данс бүртгэлд тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

### 3.2.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сулрах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

### 3.2.3. Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2, 7.1, 9.1 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллах;

#### 3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

### 3.3. Дотоод хяналттай холбоотой асуудал

#### 3.3.1. Илрүүлэлт

Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор, тусгай хамгаалалттай газарт байрладаг Тэрэлж голын эх Даваат гэдэг газар 2008 онд нутгийн иргэдийн хандиваар барьсан 4x5 метрийн хэмжээтэй суурьгүй модон торхыг Газарзүй, геоэкологийн хүрээлэн /Хуучнаар Газарзүйн хүрээлэн/-гийн санхүүгийн тайланд 2008 онд 3.6 сая төгрөгөөр дуусаагүй барилгад бүртгэсэн, хөрөнгийг ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлээгүй байна.

#### 3.3.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгө ашиглагдахгүй байх, үрэгдэх, эвдрэлд өртөх, үндсэн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт алдагдах;

#### 3.3.3. Өгсөн зөвлөмж:

Дуусаагүй барилгад бүртгэлтэй 4x5 метрийн хэмжээтэй суурьгүй модон торхыг газар дээр нь үзэж, шалгаж, шийдвэрлэх тодорхой арга хэмжээ авах;

#### 3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

### 3.4. Дотоод хяналттай холбоотой асуудал

#### 3.4.1 Илрүүлэлт

ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдэд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 55-85 насны 63 хүн ажиллаж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байна” 46 дугаар зүйлийн 46.2-т “Төрийн жинхэнэ албан хаагчийг дараах үндэслэлээр төрийн албанаас чөлөөлнө”, 46.2.2-т “тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн”, 46.2.3-т “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн” гэж заасантай нийцэхгүй байна.

#### 3.4.2. Эрсдэл:

Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль журмын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, батлагдсан төсвийг хэтрүүлсэн, зориулалт бусаар зарцуулсан байх;

#### 3.4.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, тэтгэвэр тогтоолгосон ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах;

#### 3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,918,735.5</b>	<b>2,062,332.8</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,585.5	366,601.6
33	АВЛАГА	907,950.8	549,247.6
34	УРЬДЧИЛГАА	33,018.9	208,305.6
35	БАРАА МАТЕРИАЛ	974,180.2	938,178.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,706,801.5</b>	<b>32,570,724.2</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>30,706,801.5</b>	<b>32,570,724.2</b>
39200	Биет хөрөнгө	24,600,719.4	26,547,374.2
39300	Биет бус хөрөнгө	6,106,082.1	6,023,350.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>32,625,537.0</b>	<b>34,633,057.0</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>20,713.4</b>	<b>2,961.5</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>20,713.4</b>	<b>2,961.5</b>
41300	Өглөг	20,713.4	2,961.5
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>32,604,823.6</b>	<b>34,630,095.5</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	32,604,823.6	34,630,095.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,060,961.8	23,944,588.5
51200	Хуримтлагдсан үр дүн	-3,697,878.8	793,822.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,241,740.6	9,891,684.8
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>32,625,537.0</b>	<b>34,633,057.0</b>

##### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>18,914,893.6</b>	<b>37,436,463.4</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,104,932.7</b>	<b>15,450,780.6</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,104,932.7	15,450,780.6
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>17,809,960.9</b>	<b>21,985,682.8</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>19,513,801.3</b>	<b>22,573,499.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>19,513,801.3</b>	<b>22,573,499.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>19,290,370.8</b>	<b>22,407,662.6</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,067,662.9	13,104,130.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,295,418.2	1,598,988.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	538,200.6	562,846.6
2104	Хангамж, бараа материалын зардал	403,712.8	587,554.7
2105	Нормативт зардал	2,260.7	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	583,155.9	407,508.2
2107	Томилолт, зочны зардал	438,256.8	400,235.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,186,614.7	3,356,160.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,775,088.3	2,390,239.3
213	Урсгал шилжүүлэг	223,430.4	165,837.3
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>-598,907.7</b>	<b>14,862,963.5</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.0</b>	<b>6.1</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>557,973.4</b>	<b>12,151,816.3</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>-1,156,881.1</b>	<b>2,711,153.2</b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>19,044,868.9</b>	<b>22,401,007.5</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	253,689.1	210,803.6
120	Нийтлэг татварын бус орлого	253,689.1	210,803.6
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>18,791,179.7</b>	<b>22,190,203.9</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>18,482,179.1</b>	<b>21,225,891.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>18,482,179.1</b>	<b>21,225,891.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>17,454,756.5</b>	<b>20,525,812.4</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,030,614.2	13,062,843.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,286,246.7	1,585,915.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	535,169.9	555,592.6
2104	Хангамж, бараа материалын зардал	341,852.8	386,186.9
2105	Нормативт зардал	2,580.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	301,847.6	511,947.6
2107	Томилолт, зочны зардал	435,914.7	457,060.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,232,473.0	3,740,639.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	288,057.6	225,626.3
213	Урсгал шилжүүлэг	1,027,422.6	700,079.2
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>562,689.8</b>	<b>1,175,115.9</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>561,703.1</b>	<b>812,099.8</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>561,703.1</b>	<b>812,099.8</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	561,703.1	812,099.8
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(561,703.1)</b>	<b>(812,099.8)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>986.7</b>	<b>363,016.1</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,598.8	3,585.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,585.5	366,601.6

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,089,356.9	-	16,089,356.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(18,268.1)	-	(18,268.1)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>16,071,088.8</b>	<b>-</b>	<b>16,071,088.8</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	11,964,171.0	-	11,964,171.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	5,726,444.9	-	5,726,444.9
Тайлант үеийн үр дүн	(1,156,881.1)	-	(1,156,881.1)
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>32,604,823.6</b>	<b>-</b>	<b>32,604,823.6</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,327,849.1	-	5,327,849.1
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>37,932,672.7</b>	<b>-</b>	<b>37,932,672.7</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(6,349,448.6)	-	(6,349,448.6)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	335,718.2	-	335,718.2
Тайлант үеийн үр дүн	2,711,153.2	-	2,711,153.2
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>34,630,095.5</b>	<b>-</b>	<b>34,630,095.5</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	992.3	992.3	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>16,820,414.8</b>	<b>16,791,353.6</b>	<b>29,061.2</b>	<b>99.8</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>16,820,414.8</b>	<b>16,791,353.6</b>	<b>29,061.2</b>	<b>99.8</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>16,707,497.4</b>	<b>16,684,814.8</b>	<b>22,682.6</b>	<b>99.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>12,448,235.8</b>	<b>12,437,006.8</b>	<b>11,229.0</b>	<b>99.9</b>
Үндсэн цалин	10,787,237.0	10,746,703.9	40,533.1	99.6
Нэмэгдэл	1,300,874.0	1,333,379.0	(32,505.0)	102.5
Унаа хоолны хөнгөлөлт	344,924.8	344,269.9	654.9	99.8
Урамшуулал	15,200.0	12,654.0	2,546.0	83.2
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,526,573.0</b>	<b>1,523,744.1</b>	<b>2,828.9</b>	<b>99.8</b>
Тэтгэврийн даатгал	1,041,813.7	1,051,103.5	(9,289.8)	100.9
Тэтгэмжийн даатгал	121,189.9	135,085.0	(13,895.1)	111.5
ҮОМШӨ-ний даатгал	96,951.5	95,375.0	1,576.5	98.4
Ажилгүйдлийн даатгал	24,238.4	32,694.8	(8,456.4)	134.9
Эрүүл мэндийн даатгал	242,379.5	209,485.9	32,893.6	86.4
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>548,707.8</b>	<b>548,593.7</b>	<b>114.1</b>	<b>100.0</b>
Гэрэл, цахилгаан	267,165.6	291,869.1	(24,703.5)	109.2
Түлш, халаалт	207,653.1	180,707.5	26,945.6	87.0
Цэвэр, бохир ус	41,855.1	43,983.1	(2,128.0)	105.1
Байрны түрээс	32,034.0	32,034.0	-	100.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>208,573.0</b>	<b>204,429.1</b>	<b>4,143.9</b>	<b>98.0</b>
Бичиг хэрэг	30,363.1	36,203.8	(5,840.7)	119.2
Тээвэр, шатахуун	24,777.8	15,152.7	9,625.1	61.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,172.3	52,042.5	129.8	99.8
Ном, хэвлэл	48,481.0	47,318.7	1,162.3	97.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	10,668.7	9,924.9	743.8	93.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,110.1	43,786.3	(1,676.2)	104.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>472,200.1</b>	<b>472,163.3</b>	<b>36.8</b>	<b>100.0</b>
Багаж, техник, хэрэгсэл	236,125.0	245,268.5	(9,143.5)	103.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,382.0	18,382.0	-	100.0
Урсгал засвар	217,693.1	208,512.8	9,180.3	95.8
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>136,109.0</b>	<b>131,180.4</b>	<b>4,928.6</b>	<b>96.4</b>
Дотоод албан томилолт	136,109.0	131,180.4	4,928.6	96.4
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	<b>1,260,985.6</b>	<b>1,261,584.3</b>	<b>(598.7)</b>	<b>100.0</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	1,220,332.0	1,221,932.1	(1,600.1)	100.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,480.0	19,480.0	-	100.0
Даатгалын үйлчилгээ	3,260.5	2,873.0	387.5	88.1
Тээврийн хэрэгслийн татвар	2,508.6	2,072.3	436.3	82.6
Тээврийн хэрэгслийн оношилгоо	462.0	293.0	169.0	63.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,503.0	1,503.0	-	100.0
Газрын төлбөр	13,439.5	13,430.9	8.6	99.9
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>106,113.1</b>	<b>106,113.0</b>	<b>0.1</b>	<b>100.0</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	13,793.3	13,793.3	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	92,319.8	92,319.7	0.1	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>106,871.9</b>	<b>106,538.9</b>	<b>333.0</b>	<b>99.7</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>6,045.5</b>	<b>6,017.4</b>	<b>28.1</b>	<b>99.5</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	6,045.5	6,017.4	28.1	99.5
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>100,826.4</b>	<b>100,521.4</b>	<b>305.0</b>	<b>99.7</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,373.0	13,207.0	166.0	98.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,926.4	38,926.3	0.1	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,527.0	48,388.1	138.9	99.7
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>16,814,369.3</b>	<b>16,790,361.3</b>	<b>24,008.0</b>	<b>99.9</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>16,592,004.3</b>	<b>16,575,323.4</b>	<b>16,680.9</b>	<b>99.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	16,592,004.3	16,575,323.4	16,680.9	99.9
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>222,365.0</b>	<b>215,037.9</b>	<b>7,327.1</b>	<b>96.7</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	156,425.0	150,602.9	5,822.1	96.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,940.0	64,435.0	1,505.0	97.7
Төсвийн байгууллага	18	14	4	77.8
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1382</b>	<b>1206</b>	<b>176</b>	<b>87.3</b>

Шинжлэх ухааны академийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Удирдах ажилтан	18	15	3	83.3
Гүйцэтгэх ажилтан	1126	1007	119	89.4
Үйлчлэх ажилтан	238	184	54	77.3

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,085.5
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,234,683.5</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,234,683.5</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,200,130.1</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>625,836.7</b>
Үндсэн цалин	224,309.2
Урамшуулал	2,940.8
Гэрээт ажлын хөлс	398,586.6
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>62,171.0</b>
Тэтгэврийн даатгал	61,731.8
Тэтгэмжийн даатгал	109.8
ҮОМШӨ-ний даатгал	87.9
Ажилгүйдлийн даатгал	22.0
Эрүүл мэндийн даатгал	219.6
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,998.9</b>
Гэрэл, цахилгаан	5,948.5
Түлш, халаалт	1,050.4
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>183,386.9</b>
Бичиг хэрэг	8,185.3
Тээвэр, шатахуун	69,114.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,174.3
Ном, хэвлэл	59,709.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	230.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,973.3
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>565,415.2</b>
Багаж, техник, хэрэгсэл	459,910.3
Тавилга	12,735.2
Урсгал засвар	92,769.7
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>325,880.5</b>
Гадаад албан томилолт	35,783.5
Дотоод албан томилолт	289,397.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	700.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,768,562.9</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,753,216.8
Тээврийн хэрэгслийн татвар	78.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,200.0
Газрын төлбөр	68.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>120,415.3</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	52,235.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	68,180.2
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>541,462.7</b>
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	541,462.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,553.4</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,553.4</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,553.4
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,598,199.6</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,598,199.6</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	733,772.1
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,477,910.7
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,386,516.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	366,601.6

## 5 Хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Аудитын нэр:</b>	<b>Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</b>	<b>Аудитын код:</b>
<b>Огноо</b>	<b>2019 он</b>	<b>САГ-2020/15/СТА-ТТЗ</b>
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Шинжлэх ухааны академи</b>	<b>сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1.	ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн ажлын цагийн бүртгэл хангалтгүй байна. Мөн үндсэн ажлаас гадуур ажил эрхэлж байгаа 35 хүний ажлын цаг бүртгэгдэхгүй цалинжиж байна.	-	Зөвлөмж	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	Б.Авид А.Баярбаатар
2.	Тайлант онд ТӨБЗГ-ын 13 албан бичгийн дагуу 745.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсныг нэр бүхий хүрээлэнгүүд 744.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө актлаж, 1.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаагүй үлдээсэн байна.	1.1	Зөвлөмж	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	Б.Авид А.Баярбаатар
3.	2008 онд нутгийн иргэдийн хандиваар барьсан 4x5 метрийн хэмжээтэй суурьгүй модон торхыг Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн санхүүгийн тайланд 2008 онд 3.6 сая төгрөгөөр дуусаагүй барилгад бүртгэсэн ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлээгүй байна.	3.6	Зөвлөмж	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	Б.Авид А.Баярбаатар
4.	ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдэд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 55-85 насны 63 хүн ажиллаж байна	-	Зөвлөмж	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	Б.Авид А.Баярбаатар

